

## **Монголбанкны хэвлэлийн хурлаас... 2017.06.15**

*Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл хуваарийн дагуу 2017.06.15-нд хуралдаж бодлогын хүүг 2 пунктээр бууруулж 12 хувь болгох шийдвэр гаргасан. Мөнгөний бодлогын зөвлөлийн шийдвэрийг танилцуулах хэвлэлийн бага хурлын үеэр сэтгүүлчдийн асуусан асуулт, хариултыг хүргэж байна.*

**-Мөнгөний бодлогын хүүг бууруулах болсон гол шалтгаан юу вэ. Бодлогын хүү буурснаар зээлийн хүү давхар буурах боломж бүрдэх байх. Зээлийн хүү буурах хугацааг хэрхэн харж байна вэ?**

**МБГ-ын захирал Б.Баярдаваа:**

“Бодлогын хүү буурснаар зах зээлд маш тодорхой нэг мессэж өгч байна. Бодлогын хүү буурснаар Засгийн газрын бондын хүү буурна. Түүнийг дагаад хадгаламжийн хүү буурна. Хадгаламжийн хүү буурснаар зээлийн хүү буурах боломж нээгдэж байна. Бодлогын хүүгийн нөлөөлөл зах зээл дээр дөрвөн улирлын дараа хамгийн хүчтэй мэдрэгддэг.

**-Өмнө нь Монголбанк 2016 оны наймдугаар сард бодлогын хүүг огцом нэмэгдүүлсэн. Гэвч тэрнээс хойш бага багаар бууруулсаар эргээд 12 хувь дээр ирлээ. Бодлогын хүүг нэмэгдүүлсэн өмнөх шийдвэрийн үр дүн хангалттай гарсан гэж үзэх үү?**

-2016 оны наймдугаар сард бид Бодлогын хүүг 15 хувьд хүргэж нэмэгдүүлж байсан. Тухайн шийдвэрийг гаргах үед харгалзан үзэж байсан нөхцөлүүд эерэг чиглэлд өөрчлөгдөж байгаа учраас энэ шийдвэрийг гаргасан. Тухайлбал тухайн үед бид бодлогын хүүг нэмсэн шийдвэр гаргаснаа мэдэгдэж байхад төсвийн дарамт өндөр, тодорхой бус байдал их байсан. ОУВС-тай тохирсон хөтөлбөрийн хүрээнд батлагдсан төсвийн тодотголын хууль, төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдлээс харвал төсвийн бодлого мөнгөний бодлого зөөлрөх орон зайг олгож байна. Өөрөөр хэлбэл, төсвийн бодлого дунд, урт хугацаандаа өрийн тогтвортой байдлыг хангах чиглэл рүү өөрчлөгдсөн. Хоёрдугаарт төлбөрийн тэнцэл буюу гадаад тэнцэл дээр ирж байсан дарамтууд нааштайгаар шийдэгдэж байна. Энэ нь бидний санаа зовж байсан хоёр дахь хүчин зүйл юм.

**-Гуравдугаар сард Мөнгөний бодлогын зөвлөл хуралдаж, тодорхой бус байдал байсаар байгаа учраас бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэр гаргасан. Тэр үетэй харьцуулахад одоо гадаад, дотоод нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөн бэ?**

-Гуравдугаар сарын хуралтай харьцуулахад гадаад эдийн засгийн төлөв байдал бидэнд нааштайгаар өөрчлөгдөж байна. Тухайлбал тухайн үед зэсийн үнэ бидний төсөөлж байснаас 300-500 ам.доллараар илүү өслөө. Худалдааны гол түнш орон болох БНХАУ-ын эдийн засгийн өсөлт шинжээчдийн хүлээж байснаас өндөр түвшинд 6.9 хувиар 2017 оны нэгдүгээр улиралд өссөн. Сүүлийн хоёр жил уналттай байсан ОХУ-ын эдийн засаг нэгдүгээр улиралд анх удаагаа 0.5 хувийн эерэг өсөлттэй гарч байна. Цаашдаа шинжээчид энэ өсөлт тогтвортой нэмэгдэнэ гэж харж байна. Түүнчлэн манай улсын гурав дахь том худалдааны түнш болох евро бүсийн эдийн засаг харьцангуй тогтвортой байхаар мэдээллүүд гарч ирж байгаа. Энэ бол бидний гадаад эдийн засагт гарч байгаа өөрчлөлтүүд юм. Дээрээс нь дотоодын эдийн засгийн хувьд бодлогын тодорхой бус

байдал тодорхой хэмжээнд санаа зовж байсан. Тодруулбал, богино хугацаат гадаад өрийн дарамтыг хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг асуудал анхаарал татаж байсан. Хөгжлийн банкны 580 сая ам.долларыг хэрхэн яаж шийдвэрлэх вэ гэдэг асуудал гуравдугаар сард амжилттайгаар шийдвэрлэгдсэн. Өрийн асуудалтай холбоотойгоор гадаад зах зээл дээр хөрөнгө оруулагчид Монголын эдийн засгийн болгоомжилсон байдалтай харж байсан. Энэ нь тухайн үед байсан хүүний өсөлтөөс харагддаг. Өөрөөр хэлбэл Чингис бондын гадаад зах зээл дээр арилжаалагдаж байгаа хүү 20 хувь руу дөхсөн бол Хөгжлийн банкны бондын хүү бол 30 хувь руу дөхөж очсон. Одоо энэ тодорхой бус байдлууд арилаад ирэхээр гадаад болон дотоод зах зээл дээр эерэг хүлээлт үүсч байна. Хөрөнгө оруулагчдын итгэл, мөн зах зээлд оролцогчдын итгэл сэргэж байгаа нь харагдаж эхэллээ. 5 жилийн хугацаатай Чингис бондын хүү 4 орчим хувьтай, 10 жилийнх нь 6 орчим хувьтай болж, буурч байгаа учраас эдийн засаг сэргэж эхэлсэн гэсэн дүгнэлтийг өгч болох юм. Мөн инфляцийн төсөөллөөр инфляци нь дунд хугацаанд зорилтот түвшинд тогтвортой байх төсөөлөлтэй байна. Энэ нь мөнгөний бодлогыг зөөлөрч, бодит секторыг дэмжих боломжийг олгож байгаа учраас энэ удаагийн мөнгөний бодлогын зөвлөл хуралдаж бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулах шийдвэр гаргасан.

**-Төсвийн бодлого дээр гарч байгаа өөрчлөлтүүдийг хэрхэн харж байна вэ. Мөнгөний бодлоготой энэ нь уялдаж чадаж байна уу?**

**МБГ-ын захирал Б.Баярдаваа:**

-Та бүхэн төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, төсвийн батлагдсан хуулийг харсан бол төсвийн алдагдлын хэмжээ 2016 онд 18 хувь, 20 хувь руу ч хүрэх эрсдэлтэй байсан. Одоо эргээд харахад алдагдал энэ онд 9.5 хувь, ирэх жил 6 хувь, тэрний дараа жил 5 хувь болж, буурахаар байгаа. Энэ нь төсөв дунд, урт хугацаандаа тогтвортой байдлаа хангах чиглэл рүү өөрчлөгдөж байна гэсэн үг юм. Энэ нь төсвийн бодлого талаас чангарах төлөв ажиглагдаж байгааг илтгэж байна.

**-Бодлогын хүүг 2-оос илүү нэгж хувиар бууруулах боломж байсан уу?**

**МБГ-ын захирал Б.Баярдаваа:**

-Мөнгөний бодлогын зөвлөлийн хурал дээр зөвлөлийн хоёр гишүүн 2-оос илүү хувиар буулгая гэсэн санал дэвшүүлсэн. Гэхдээ олонхийн саналаар энэ удаад 2 нэгж хувиар буулгах шийдвэр гарсан. Үүнээс гадна чанаргүй зээлийн хувийг мөн бодлогын зөвлөлийн хурал дээр ярилцсан. Сүүлийн үеийн мэдээллийг харвал чанаргүй зээлийг бүрдүүлж буй 2 салбар байгаа юм. Нэгдүгээрт уул уурхайн салбар, хоёрдугаарт, худалдааны салбар. Статистикийн тооноос харахад уул уурхайн салбарын өсөлт хасах хувьтай харагдаж байгаа. Үүнд нөлөөлж буй гол хүчин зүйл нь Оюутолгойн үйлдвэрлэлийн зэс, алтны агууламж нь үлэмж хэмжээгээр буурсантай холбоотой. Үүнийг хасаад бусад уул уурхайн секторын өсөлтийг харвал 15.5 хувийн өсөлттэй гарсан байгаа. Тэгэхээр уул уурхайн салбарт өсөлт эхэлж байна гэсэн үг. Энэ өсөлтөд үнэ нөлөөлж байна. Үнийн өсөлтийг дагаад үйлдвэрлэлийн хэмжээ ч нэмэгдэж байна. Энэ нь уул уурхайн салбарт бизнес явуулж байгаа ААН-үүдийн бизнест таатай нөхцөлийг бий болгож, бизнесийн ашигт ажиллагаа нэмэгдэх боломжийг олгож байна. Тэгэхээр өмнө нь зээлээ төлж чадахгүй байсан чанаргүй зээлийг тодорхойлж байгаа зүйл маань эргээд гайгүй болно гэсэн хүлээлттэй байна. Хоёрдугаарт, энэ салбарын идэвхжил нь цаашлаад худалдааны салбарт хамгийн түрүүнд сайнаар нөлөөлнө. Уул уурхайн салбар дээр явж буй томоохон хөрөнгө оруулалтын нөлөөгөөр худалдаа идэвхжиж

байна. Эдийн засаг идэвхжээд өсөлт сайжраад эхлэхээр зээлийн эргэн төлөлт сайжирна гэсэн хэлэлцүүлэг мөнгөний бодлогын зөвлөл дээр явагдсан байгаа.

**-Цаашдаа бодлогын хүүг бууруулах боломжтой юу?**

**МБГ-ын захирал Б.Баярдаваа:**

-Цаашдаа бууруулах эсэхийг одоо хэлэх боломжгүй. Өөрөөр хэлбэл, одоо гаргасан бодлогын шийдвэрийн үр дүнг бид үзнэ. Бодит эдийн засгийн II улирлын тоо ямар гарч ирэх вэ гэдэг дээр үндэслэн бид таамаглалаа шинэчилж боловсруулна. Бидний инфляцийн зорилт, бодит инфляцийн гүйцэтгэл, ирээдүйд хүлээгдэж байгаа инфляцийн төсөөлөл яаж өөрчлөгдөх вэ, эдийн засгийн өсөлт хэрхэх вэ, санхүүгийн систем дээр байгаа өөрчлөлт яаж өрнөх гэх зэргээс шалтгаалан дараагийн бодлогын санал, бодлогын зөвлөлийн хурал явагдана. Иймд өнөөдөр хараахан хэлэх боломжгүй. Мөнгөний бодлогын зөвлөлийн дараагийн хурал есдүгээр сарын дундуур болно.